

[2017-05-02 10:54:12](#)

<http://leaders.mn/14548.html>



Австраал Улсын эмэгтэйчүүд, охидын асуудал хариуцсан Австралийн элчин сайд Шармэн Стөүн Монголд тавдугаар сарын 2-ны өдөр айлчилж байна. Хатагтай Шармэн Стөүн өнөөдөр Гадаад харилцааны яаманд эмэгтэйчүүд, охидын асуудлаар “Манлайлалд эмэгтэйчүүдийн үүрэг” дугуй ширээний хэлэлцүүлэг хийнэ. Хэлэлцүүлэгт УИХ-ын эмэгтэй гишүүд, Гадаад хэргийн дэд сайд Б.Батцэцэг, эмэгтэй сайд, дэд сайдууд оролцох юм байна.

Элчин сайд Стөүн 5 дугаар сарын 2-ноос 4-ний өдрүүдэд Монголд ажиллана. Тэрээр айлчлалынхаа хугацаанд УИХ-ын гишүүд, бизнес, иргэний нийгмийн салбарын төлөөлөл болсон эмэгтэйчүүдтэй уулзаж, эмэгтэйчүүдэд илүү эрх мэдэл олгох, хүйсийн тэгш эрхийг хангах, хүүхэд, эмэгтэйчүүдийн хүчирхийллийг таслан зогсоох асуудлыг хөндөн ярилцахээр төлөвлөжээ. Доктор Стөүн нь эмэгтэйчүүд, охидын асуудал хариуцсан Австралийн Элчин сайдын албанд 2016 онд томилогдож, 2017 оны 1 дүгээр сараа ажиллаж байгаа гурав дахь эмэгтэй аж.

Тэрээр Австралийн парламентад 20 жил ажиллахдаа Австрали- Монголын парламентийн бүлгийн даргын албыг хашиж байсан. Түүний энэ удаагийн айлчлал Австрали, Монголын дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ойн хүрээнд болж байна. Австралийн дипломат харилцаа, хөгжлийн бодлого, батлан хамгаалахын асуудлууд нь эмэгтэйчүүд, охидын эрхийг хамгаалах, тэднийг илүү эрх мэдэлтэй болгоход чиглэгдэх ёстой хэмээн үзэж, 2011 онд Австралийн Засгийн Газар Эмэгтэйчүүд, охидын асуудал хариуцсан Элчин сайдын албан тушаалыг бий болгожээ. Шармэн Стөүн “Улс төр, эдийн засаг, нийгмийн асуудлуудад эмэгтэйчүүдийн тэгш оролцоог дэлхий даяар дэмжсэнээр, энэ алба дэлхий дахины хөгжлийг урагшлуулж, энх тайван, тогтвортой байдлыг хангахад хувь нэмрээ оруулна гэж үздэг.” гэж онцлон хэлжээ.